

Завхан аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын  
газар, нутгийн захиргааны байгууллагын өргөдөл гомдол шийдвэрлэлтийн 2017  
оны тайлан

2017.12.28

Улиастай

Завхан аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт болон сум байгууллагуудад ирсэн өргөдөл, гомдлыг "Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" Монгол улсын хууль, "Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоолын дагуу иргэдээс мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар болон амаар, бичгээр ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг аль болох хүртээмжтэй, шуурхай, чирэгдэлгүй хүргэх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга нар доорх хуваарийн дагуу иргэдтэй биечлэн уулзаж, өргөдөл, гомдлыг амаар болон бичгээр хүлээн авч шийдвэрлэн хариуг өгч, бусад өдрүүдэд Тамгын газрын дарга, хэлтсийн дарга нар иргэдийг хүлээн авч уулзаж өргөдөл гомдлыг шийдвэрлэн ажиллаж байна.

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ИРГЭДТЭЙ  
УУЛЗАХ ЦАГИЙН ХУВААРЬ**

Д/Д	Иргэдтэй уулзах гариг	Цагийн хуваарь
	Мягмар гариг	10 <sup>00</sup> -13 <sup>00</sup> , 14 <sup>00</sup> -18 <sup>00</sup> цаг

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ НАРЫН ИРГЭДТЭЙ  
УУЛЗАХ ЦАГИЙН ХУВААРЬ:**

Д/Д	Хүлээн авах өдрүүд	Цагийн хуваарь
1	Лхагва гариг	10 <sup>00</sup> -13 <sup>00</sup> , 14 <sup>00</sup> -18 <sup>00</sup> цаг
2	Пүрэв гариг	10 <sup>00</sup> -13 <sup>00</sup> , 14 <sup>00</sup> -18 <sup>00</sup> цаг

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ИРГЭДТЭЙ УУЛЗАХ ЦАГИЙН ХУВААРЬ:**


Д/Д	Хүлээн авах өдрүүд	Цагийн хуваарь
1	Баасан гариг	10 <sup>00</sup> -13 <sup>00</sup> , 14 <sup>00</sup> -18 <sup>00</sup> цаг

Иргэдээс аймгийн Засаг дарга болон түүний Тамгын газарт 2017 онд 217 өргөдөл хүлээн авч холбогдох албан тушаалтанд уламжлан 208 өргөдлийг шийдвэрлүүлж 9 өргөдөл шийдвэрлэх хугацаа нь хүлээгдэж шийдвэрлэлт 95,6 хувьтай байна.




Нутгийн захиргааны байгууллагуудад иргэдээс 2448 өргөдөл гомдлыг хүлээн авч 2361 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариу өгч, 35 өргөдлийг бусад байгууллагад шилжүүлж, 7 өргөдлийг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэж, 45 өргөдөл хугацаа болоогүй хүлээгдэж байна. Нутгийн захиргааны байгууллагад иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлт 98,1 хувьтай байна.

Аймгийн Засаг даргын иргэдээ сонсох 70461212 утсанд 2017 онд 75 санал, хүсэлт ирсэнийг холбогдох албан тушаалтанд хүргүүлж 71 нь шийдвэрлэгдэж 4 санал, хүсэлт хугацаа болоогүй хүлээгдэж шийдвэрлэлтийн хувь 94,6 хувь байна. Засгийн газрын 11-11 төвд 59 санал, хүсэлт ирсэнийг холбогдох албан тушаалтанд



хүргүүлж 56 нь шийдвэрлэгдэж 3 санал, хүсэлт хугацаа болоогүй хүлээгдэж шийдвэрлэлтийн хувь 93,2 хувь байна.



**Өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэхдээ тухай бүр дүгнэлт хийж, хяналт шинжилгээ үнэлгээг хийж биелэлтийг тооцон ажиллаж байна.**

### Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал

№	Завхан аймаг	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлт хувь
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй	
1	Аймгийн Засаг даргын Тамгын газар	351	255	42	41	13	96,2%
2	Нутгийн захиргааны байгууллага	2448	2361	35	7	45	98,1%
<b>2017 оны дүн</b>		<b>2799</b>	<b>2616</b>	<b>77</b>	<b>48</b>	<b>58</b>	<b>97,1%</b>

**Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлт /хэлбэрээр/**

№	Завхан аймаг	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт	Үүнээс:					
			Бичгээр	11-11 төв	Цахим хэлбэрээр	Утсаар хандсан	Биечлэн уулзсан	Бусад
1	Аймгийн Засаг даргын Тамгын газар	351	213	59	-	75	4	-
2	Нутгийн захиргааны байгууллага	2448	1932	0	-	115	401	-
<b>2017 оны дүн</b>		<b>2799</b>	<b>2145</b>	<b>59</b>	<b>-</b>	<b>190</b>	<b>405</b>	<b>-</b>

**Өргөдөл, гомдол, санал хүсэлтийн агуулга**

№	Аймгийн нэр	Зонхилж байгаа асуудал /тоо, нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь/
1	Завхан аймаг	Нийт 2799 өргөдлөөс Хүсэлт 2289 / 81,7% Гомдол 286 / 10,2% Санал 224 / 8,0%
		1. Нийгмийн халамж, иргэний бүртгэлийн талаар 1186 / 42,3%
		2. Ажилд орох, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой 1035 / 36,9%
		3. Газар олголт, газрын маргааны асуудал 173 / 6,2%
		4. Тусгай зөвшөөрөл хүссэн 91 / 3,3%
		5. Тусламж хүссэн 72 / 2,6%
		6. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 71 / 2,5%
		7. Цалин, тэтгэмжтэй холбоотой 59 / 2,1%
		8. Нийгмийн даатгалын чиглэлээр 52 / 1,9%
		9. Байгаль орчины чиглэлээр 13 / 0,6%
		10. бусад асуудлаар 47 / 1,6%

**ТАНИЛЦАЖ ХЯНАСАН:**

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН

ГАЗРЫН ДАРГА

Л.ЛХАМСҮРЭН

**ТАЙЛАНГ НЭГТГЭЖ БОЛОВСРУУЛСАН:**

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН

ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Н.ЯДАМЦОО